

## Шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүдийн оролцоон дахь сонгуулийн тогтолцооны нөлөө

Нэргүйн Үүрийнтуяа 

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Багшийн Сургуулийн Монгол хэл, Нийгмийн ухааны тэнхимийн багш, докторант, Улаанбаатар, Монгол Улс.

Хүлээн авсан - Received:  
2024-10-24

Засварласан - Revised:  
2024-11-30

Хэвлэгдсэн - Published:  
2024-12-30

[uuriintuya@msue.edu.mn](mailto:uuriintuya@msue.edu.mn)

ORCID: [0009-0001-2376-0104](https://orcid.org/0009-0001-2376-0104)



© 2024, Author(s)

**Хураангуй:** Хууль тогтоох байгууллагад жендэрийн тэгш байдлыг хангах нь ардчилал, хүний эрх, тэгш байдлыг тогтооход чухал нөлөөтэй. Монгол улсын Засгийн газар дэлхийн хамтын ажиллагааны байгууллагуудын өмнө хүлээсэн үүрэг, амлалтаа хараахан биелүүлээгүй байгаа нь шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх боломжийг судлахад хүргэдэг. Энэ өгүүлэлээрээ улс төрийн сонгуулийн тогтолцооны онол болон дэлхийн улс орнуудын сонгуулийн тогтолцоо болоод эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоо, төлөөлөл хоорондын хамаарлыг судалсан эмпирик судалгааны үр дүнд тулгуурлан Монголын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны төлөв байдлыг сонгуулийн тогтолцооны өөрчлөлттэй холбон 1992 оноос өнөөг хүртэл түүхчлэн авч үзлээ. 2024 оны сонгуулийн үр дүнд дүгнэлт хийж, эмэгтэйчүүдийн оролцоонд сонгуулийн тогтолцоо шийдвэрлэх үүрэгтэй болохыг тодорхойлов.

**Түлхүүр үг:** *Эмэгтэйчүүдийн оролцоо, квот, сонгуулийн тогтолцоо, улс төрийн нам, жендэрийн эрх тэгш байдал, тогтвортой хөгжлийн зорилт*

### Оршил

Монгол Улсын их хурлын ээлжит сонгууль 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдөр болж өнгөрлөө. Сонгуульд нийт 1336 хүн дэвшсэнээс 519 нь эмэгтэйчүүд байсан бөгөөд тэдний 32 нь УИХ-д сонгогдсон. 13 тойрогт өрсөлдөн ялалт байгуулсан 8, намын жагсаалтаар 24 эмэгтэй тус тус суудал авлаа. Энэ нь УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 1990 оноос хойш анх удаа амжилтыг 8 хувиар ахиулж 25 хувьд хүрсэн хэдий ч анхаарал татахуйц асуудлууд ажиглагдаж байна. Тойрогт өрсөлдөн сонгогдсон 78 гишүүдийн 90 хувь буюу 70 нь эрэгтэй, 10 хувь буюу 8 нь эмэгтэй байгаа нь хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцоо тийм ч хангалттай бус байгааг харуулж байна. Үүнийг нарийвчлан авч үзвэл сонгуулийн тойрогт өрсөлдөн суудал авсан эмэгтэй гишүүдийн 6 нь МАН, 2 нь АН, бусад улс төрийн нам, эвслээс эмэгтэйчүүд тойргоос өрсөлдөн суудал хараахан авч чадаагүй.

УИХ-д жендэрийн тэгш байдлыг хангах нь нийгэмд ардчилал, хүний эрх, жендэрийн тэгш байдлыг тогтооход чухал нөлөөтэй. 2024 оны байдлаар Дэлхийн Эдийн Засгийн Форумгаас гаргадаг жендэрийн зөрүүтэй байдлын үзүүлэлтээр (Global Gender Gap Report, 2024) дэлхийн улс орнууд жендэрийн тэгш байдлыг хангахад дунджаар 68.6%-тай байна (Энэ тоо 2024.12.31-ийг дуусаад

өөрчлөгдөнө). Монгол улс нь 70.5% үзүүлэлтээрээ нийт 146 орны дунд 85 дугаар байранд орж (Global Gender Gap Report, 2024) урагшилсан боловч манай улс НҮБ-ын гишүүн улсын хувьд даян дэлхийн тогтвортой хөгжлийн зорилгод хүрэх амлалт буй. Тогтвортой хөгжлийн зорилго 5-д Жендэрийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, 5.5-д Улс төр, эдийн засаг, олон нийтийн амьдралын шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийн бүрэн болон үр бүтээмжтэй оролцоо, удирдах тэнцүү боломжоор хангах (Нэгдсэн Үндэсний Байгууллага, 2016, хууд. 18)-аар заасан хэдий ч Монгол улсад жендэрийн тэгш байдлыг хангаж, тогтвортой хөгжлийн зорилт 2030 -ын хүрээнд тавьсан зорилгоо биелүүлж чадаагүй хэвээр байна.

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 5.1-д Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүнг тодорхойлохдоо I үе шат 2021-2030 онд эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэртэй байдал, түүнд тавих хяналтыг оновчтой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, тогтвортой, хяналттай засаглалыг төлөвшүүлэх үе. Үүнд:1 дүгээрт УИХ-ын хууль тогтоох, бодлого тодорхойлох, төлөөлөх, хяналт тавих чадавх сайжирч парламентын засаглал бэхэжсэн байна. 5 дугаарт Төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдалд эерэг нөлөөтэй сонгуулийн тогтолцоо бүрдэж, иргэдийн улс төрийн боловсрол дээшлэн, иргэд, сонгогчдын хариуцлага сайжирна гэх зэргээр тодорхойлон авч үзжээ. (МУ -ын Засгийн газар, 2020, хууд. 35)

Мөн 2011 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг батлан гаргасан нь нийгэмд жендэрийн тэгш эрхийн зарчим болох *“эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн амьдралд адил оролцох, хөгжлийн үр шим, нийгмийн баялагаас тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцөлийг хангах”* талаар хууль, эрх зүйн орчинд дэвшил гарсан (МУ-ын их хурал, 2011) хэдий ч өнөөдөр манай улсын сонгогчдын 51 хувийг эзэлж буй эмэгтэй хүйсийн төлөөлөл шийдвэр гаргах түвшинд хангалттай биш байна. 1990 оноос хойш хийгдсэн сонгуулиуд сонгуулийн мажоритари тогтолцооны дагуу явагдсан бөгөөд сонгууль бүрийн дараа сонгогчдын саналын дагуу хууль тогтоох байгууллага бүрэлдэж чадахгүй байгааг шүүмжилж ирсэн. Гуч гаруй жилийн тэртээгээс анхны ардчилсан өөрчлөлт хийгдэж, түүнээс хойш сонгуулийн тогтолцоог хэдэнтээ өөрчилсөн боловч монголчууд сонгуульд өгсөн санал нь Улсын Их Хурал (УИХ) дахь суудлын тоонд тусгалаа олох механизмыг боловсронгуй болгох замаар сонгуулийн үйл явцыг засаж сайжруулахаар холимог тогтолцоог хэрхэн бүрдүүлэхэд анхаарч байна (International IDEA, 2023, хууд. 4)

Ийнхүү сонгуулийн тогтолцоо нь хууль тогтоох байгууллага дахь олон ургальч ёсыг хангахад чухал үүрэгтэй нь олон судалгаагаар нотлогддог. Иймээс эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшний оролцоог сонгуулийн тогтолцоотой холбон судлах шаардлага байсаар байна.

### *Судалгааны үр дүн*

#### **Нэг. Сонгуулийн тогтолцоо эмэгтэйчүүдийн оролцоонд нөлөөтэй юу?**

**Сонгуулийн тогтолцооны онол.** Сонгуулийн тогтолцоо болон сонгох эрхийн талаар анх дэвшүүлэн тавьсан хүн бол Оросын философич, улс төр судлаач Алексис де Токвиль юм. Тэрээр XIX зуунд Америкт хийсэн судалгаагаар ардчилсан сонгуулийн тогтолцооны тухай бичсэн бөгөөд энэ нь

үндсэндээ сонгуулийн тогтолцооны онол, тэр дундаа ардчиллын явц, асуудлуудыг судалсан анхны оролдлого байв. Гэхдээ сонгуулийн тогтолцоо, түүний хөгжлийн тухай онолууд олон төрлийн философийн, улс төрийн сургалтын үр дүнд бий болсон. Тиймээс энэ асуудалд олон улс төрч, эрдэмтэд хувь нэмрээ оруулж ирсэн. XVIII зууны Францын философич Жан Жак Руссо нь сонгуулийн тогтолцооны тухай нэлээд хөндөж байсан. Тэрээр "Нийгмийн гэрээ" (1762) гэх бүтээлдээ улс төрийн оролцооны, ялангуяа сонгууль, иргэдийн оролцоо зэрэг асуудлыг авч үзсэн. Түүний үзэл баримтлал нь ардчиллын суурь зарчмууд, иргэний эрх чөлөө, төрийн хяналтаас үүдэлтэй байсан бөгөөд сонгуулийн тогтолцооны үндсийг тавьсан гэж үзэж болно. Түүнчлэн Жон Локк болон Шарль Луи Монтескье зэрэг философичид улс төрийн тогтолцооны, хуулийн зохицуулалтын асуудлуудыг судалж байсан ч, сонгуулийн тогтолцоо нь тухайн үеийн улс төрийн харилцаанд чухал байр суурь эзлэх болсон XIX зууны дунд үед буюу ардчилал хурдацтай хөгжиж байсан үед илүү тодорхой болж эхэлсэн. Түүнчлэн, Карл Маркс болон Фридрих Энгельс нар ч сонгуулийн тогтолцоог капиталист нийгмийн нэг хэсэг гэж үзэж, түүний ач холбогдол, давуу болон сул талуудыг тодорхойлсон байдаг.

Австралийн судлаач Райлли сонгуулийн тогтолцоог сонгогчдын саналыг хууль тогтоох байгууллага дахь эзлэх суудал болгон хэрхэн хуваарилахыг тодорхойлох ерөнхий дүрэм гэдэг утгаар тодорхойлсон байдаг (Бат-Оргил.А, 2021, хууд. 5). Сонгуулийн тогтолцоо (Electoral system) гэдэг нь сонгууль явуулах, санал авах, дүн гаргах, парламентад суудал хуваарилах олон арга, журам байдаг ба тэдгээр аргуудын нийлбэр цогцыг сонгуулийн систем гэнэ (Жаргал.Ж., Сарангэрэл.Л, 2012, хууд. 208). Хамгийн энгийнээр сонгуулийн тогтолцоо нь аливаа сонгуульд иргэдийн өгсөн саналыг нам, нэр дэвшигчийн авах саналын тоонд шилжүүлэх арга замыг хэлнэ. Сонгуулийн тогтолцооны ямар хувилбарыг сонгож байгаагаас шалтгаалаад тойргийн хил хязгаар тогтоох арга, сонгогчдыг бүртгэх байдал, саналын хуудасны бүтэц, санал тоолох ажиллагаа болон сонгуулийн үйл явцтай холбоотой бусад олон асуудал янз бүрээр шийдэгдэх жишээтэй. Сонгуулийн системийг дотор нь мажоритар, пропорционал, холимог гэж хуваана. Мажоритари систем (олонхын санал) гэдэг нь тухайн тойрогт олонхын санал авсан нэр дэвшигч сонгуульд ялахыг хэлнэ. Энэ нь харьцангуй олонхын саналаар сонгогдох (өрсөлдөгчөөсөө илүү олон санал авсан байх), энгийн олонхын саналаар сонгогдох (нийт саналын 50%-иас доошгүй санал авсан байх), дийлэнх олонхын саналаар сонгогдох(ихэвчлэн 60%-иас дээш санал авсан байх) гэсэн ялгаатай төрлүүдтэй. Пропорционал систем (хувь тэнцүүлэх) нь парламентад суудлыг улс төрийн намуудад сонгуульд авсан саналтай нь хувь тэнцүүлэн хуваарилахад оршино. Энэ систем нь хэд хэдэн онцлогтой парламентын суудлыг намуудад сонгуульд авсан саналтай нь хувь тэнцүүлэн хуваарилдаг, нийгэмд оршин буй олон янзын үзэл бодол, сонирхол парламентад бодитой төлөөлөгддөг, сонгогчдын тодорхой хэсгийн дэмжлэг хүлээсэн улс төрийн нам парламентад суудал авах боломжтой, сонгууль зөвхөн олон мандаттай тойрогт явагддаг зэргээрээ онцлог юм. Сонгуулийн холимог тогтолцооны онцлог нь мажоритари болон пропорциональ тогтолцооны холимог юм. Нэг хэсэг нь мажоритар, нөгөө хэсэг нь пропорциональ байна гэсэн үг. Ихэнхдээ олон мандаттай мажоритар, намын жагсаалтаар санал хураах пропорциональ хувилбарыг ашигладаг (International IDEA, 2023, хууд. 3)

### ***Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны олон улсын туршлага***

Олон улсын туршлагаас үзэхэд пропорционал тогтолцоо жендэрийн тэгш байдлыг хангахад илүү үр дүнтэй байдаг. Ардчилал, Сонгуульд туслах Олон Улсын Байгууллага (International IDEA)-ын судалгаагаар сонгуулийн пропорционал тогтолцоотой улсуудад парламент дахь эмэгтэйчүүдийн

төлөөлөл мажоритар тогтолцоотой улсуудаас хоёр дахин илүү байгааг тогтоосон байдаг (Гэрэлт-Од.Э, 2020)

Сонгуулийн тогтолцоог ангилах хамгийн нийтлэг арга нь сонгогчдын өгсөн саналыг нам, нэр дэвшигчийн хууль тогтоох байгууллагад авах суудлын тоонд хувь тэнцүүлэн хөрвүүлж байгаа үр дүнгээр ангилах явдал юм. Үүний дагуу сонгуулийн тогтолцоог Олонхын буюу мажоритар (plurality, majority), Хагас хувь тэнцүүлэх (semi-proportional), хувь тэнцүүлэх (proportional-PR), холимог (mixed) хэмээн ангилдаг. Эдгээрийг дэлхийн ихэнх улс орон сонгуульдаа ашигдаж байна (Гэрэлт-Од.Э, 2020). Дэлхийн 193 улс орныг мажоритар буюу олонхын, пропорционал буюу хувь тэнцүүлэх, холимог сонгуулийн тогтолцоотой хэмээн 3 аниллаар сүүлийн сонгуулийн мэдээгээр авч үзжээ. Эндээс сонгуулийн тогтолцоогоор нь харвал хувь тэнцүүлэх (proportional-PR) тогтолцоог хэрэглэж буй улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн өндөр буюу 27.6 хувьтай байна (НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр БНСУ-ын КОЙКА ОУБ, 2022, хууд. 46).

*Хүснэгт 1. Дэлхийн улс орнуудын сонгуулийн тогтолцоо ба эмэгтэйчүүдийн төлөөлөл*

№	Сонгуулийн тогтолцоо	Улс орны тоо	Дундаж хувь	Тэргүүлэгч орон	Хувь
1	Олонхи/мажоритар тогтолцоо	71	18.5	Куба	53.4
2	Пропорционал буюу хувь тэнцүүлэх тогтолцоо	82	27.6	Руанда	61.3
3	Холимог тогтолцоо	29	26.1	Шинэ Зеланд	48.3
4	Бусад	13			
5	Нийт	195			

Эх сурвалж: НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, БНСУ-ын КОЙКА ОУБ., “Монгол дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, гадаад орны туршлага” судалгааны тайлан. УБ., 2022 он

Пропорционал буюу хувь тэнцүүлэх тогтолцоогоор сонгуулиа явуулсан 194 улсаас 82 улсын хувьд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн дундаж 27.6 хувь байна. Азийн бүсийн дундаж үзүүлэлт 21.7 хувь, Америк бүсийнх 26.7 хувь, Европ бүсийнх 30.05 хувь, Номхон далайн бүс нутаг 21.6 хувь, ба Ойрх дорнод ба хойд бүс 19.9 хувь, Сахараас урагш Африк бүс нутаг 27.9 хувь.

Дэлхийн 194 орноос холимог тогтолцоог ашигласан 29 орон байгаа бөгөөд тэдгээрийн эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт 26.1 хувь. Азийн бүсийн дундаж үзүүлэлт 21.3 хувь, Америк бүсийнх 38.8 хувь, Европ бүсийнх 27.1 хувь, Номхон далайн бүс нутаг 48.3 хувь, ба Ойрх дорнод ба хойд бүс 18.1 хувь, Сахараас урагш Африк бүс нутаг 27.3 гэсэн хувьтай байна.

Харин олонхын буюу мажоритар тогтолцоогоор сонгуулиа явуулсан 194 орноос 71 орон байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт 18.5 хувь. Азийн бүсийн дундаж үзүүлэлт 18.9 хувь, Америк бүс 24.1 хувь, Европ 32.9 хувь, Номхон далайн бүс нутаг 7.1 хувь, ба Ойрх дорнод ба

хойд бүс 11.1 хувь, Сахараас урагш Африк бүс нутаг 18.4 гэсэн хувьтай байна (НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр БНСУ-ын КОЙКА ОУБ, 2022, хууд. 47).

*Хүснэгт 2. Улс орнуудын сонгуулийн тогтолцоо ба эмэгтэйчүүдийн эзлэх хувь, бүс нутгаар*

Бүсчлэл	Сонгуулийн тогтолцоо					
	Пропорционал		Олонхын/ мажоритар		Холимог	
	Улс орон	Хувь	Улс орон	Хувь	Улс орон	Хувь
Ази	6	21.7	14	18.9	7	21.3
Америк	17	26.7	15	24.1	3	38.8
Европ	35	30	4	32.9	9	27.1
Номхон далай	1	21.6	10	7.1	1	48.3
Ойрх Дорнод ба Хойд	7	19.9	5	11.1	3	18.1
Сахараас урагш	16	27.9	23	18.4	6	27.3
Нийт улс орны тоо/дундаж хувь	82	27.6	71	18.75	29	26.1

Эх сурвалж: НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, БНСУ-ын КОЙКА ОУБ., “Монгол дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, гадаад орны туршлага” судалгааны тайлан. УБ., 2022 он

Хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувийг улс орны хөгжлийн индексийг тооцох нэгэн үзүүлэлт болгодог. Гэвч дэлхийн 194 улс орныг бүсчлэн авч үзсэн үзүүлэлтийг харахад пропорционал буюу хувь тэнцүүлэх тогтолцоог ашигласан сонгууль бүхий улсуудад тус индекс хамгийн өндөр хувьтай байлаа.

Их Британийн улс төр судлаач, олон улсын сонгуулийн тогтолцооны шинжээч Эндрю Рейнольдс нь улс төрийн төлөөлөл, сонгуулийн тогтолцоо, ардчилалын чиглэлээр мэргэшсэн төдийгүй судалгааны гол сэдэв нь улс төрийн төлөөлөл дэх эмэгтэйчүүд, цөөнхийн эрх ашгийн асуудал. Тэрээр сонгуулийн тогтолцооны хэв маяг нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд чухал нөлөө үзүүлдэг бөгөөд пропорциональ систем нь мажоритар тогтолцоотой харьцуулахад эмэгтэйчүүдийн оролцоог илүүтэй дэмждэг болохыг (Reynolds, 547-572) нотолсон байна.

Мөн сонгуулийн тогтолцооны хэв маяг нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд хэрхэн нөлөөлдөг талаар судалгаа харилцан адилгүй үр дүнг харуулдаг боловч пропорциональ төлөөллийн тогтолцооны үр нөлөө илүү эерэг байдаг. Жишээлбэл, пропорциональ төлөөллийн систем (PR)-ийг хэрэгжүүлэх нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлж, хүйсийн ялгаварлалыг бууруулдаг болохыг Норвеги улсын сонгуулийн системийг олонхын (plurality) тогтолцооноос пропорциональ төлөөллийн систем рүү шилжүүлсэн нь эмэгтэй сонгогчдын идэвхийг мэдэгдэхүйц

нэмэгдүүлсэн. Энэ шилжилт нь өрсөлдөөн ихтэй сонгуулийн тойргуудад илүү хүчтэй нөлөө үзүүлсэн. Судалгаагаар пропорциональ төлөөллийн систем нь намын элитүүд эмэгтэй нэр дэвшигчдийг сонгогчдын жагсаалтын дээд хэсэгт байрлуулах магадлалыг нэмэгдүүлж, эмэгтэйчүүдийн сонгуульд сонгогдох боломжийг сайжруулдаг болохыг тэмдэглэсэн байна. Харин олонхын системд сонгогчдын зан төлөв намын элитүүдийн хандлагад сөргөөр нөлөөлдөг гэжээ. Дээрх дүгнэлтийг хийсэн Норвегийн судлаач Скогре сонгуулийн тогтолцоо эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд хүчтэй нөлөөлдөг бөгөөд пропорциональ төлөөллийн систем нь хүйсийн тэгш байдлыг дэмжиж, эмэгтэй нэр дэвшигчдийг сонгох магадлалыг нэмэгдүүлдэг (Skorge, 2021, pp. 538-552) болохыг судалгаагаараа тогтоосон байна.

Энэ бүгдээс дүгнэвэл сонгуулийн тогтолцооны хэв маяг нь шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн хувийн жинг нэмэгдүүлэхэд ихээхэн нөлөөтэйг харж болохоор байна.

### **Хоёр. Хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны төлөв байдал.**

Монгол улсын 1992 оны Үндсэн хуулинд улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог баталгаажуулж “хүний нас, хүйс, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно”, “улс төр, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй” (МУ -ын Их Хурал, 1992) хэмээн заасан.

Социализмын үед хууль тогтоох байгууллагын 23-25 хувь нь эмэгтэйчүүд байсан бол 1990 оноос хойш энэхүү хувийн жин буурсаар ирсэн.

Монгол улс ардчилалд шилжсэнээс хойш 9 удаагийн УИХ-ын сонгуулийг зохион байгуулсан бөгөөд шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоонд сонгуулийн тогтолцоо ихээхэн нөлөөлж буйг холбон авч үзье. Улсын их хурлын сонгууль нь 1992 онд томсогосон мажоритар, 293 хүн нэр дэвшсэнээс 10 эмэгтэй нэр дэвшиж, 4 эмэгтэй гишүүн сонгогдсон, 1996 онд жижигсэгсэн мажоритар, 302 хүн нэр дэвшсэнээс 15 эмэгтэй нэр дэвшиж, 5 эмэгтэй, 2000 онд жижигсэгсэн мажоритар, 602 хүн нэр дэвшсэнээс 46 эмэгтэй нэр дэвшиж, 6 эмэгтэй, 2004 онд жижигсэгсэн мажоритар, 244 хүн нэр дэвшсэнээс 26 эмэгтэй нэр дэвшиж, 6 эмэгтэй, 2008 онд томсогосон мажоритар, 356 хүн нэр дэвшсэнээс 62 эмэгтэй нэр дэвшиж, 3 эмэгтэй гишүүн сонгогдсон явдал нь эмэгтэй гишүүний тоо 2 дахин буурсан үзүүлэлттэй байсан. Ингээд 2012 онд холимог сонгуулийн тогтолцоогоор сонгуулийг явуулсан бөгөөд 544 хүн нэр дэвшсэнээс 174 эмэгтэй нэр дэвшиж, 11 эмэгтэй гишүүн сонгогдсон нь өмнөх сонгуулиудтай харьцуулахад хэзээ ч байгаагүй үзүүлэлт байсан. 2016 онд томсогосон мажоритари тогтолцоогоор сонгуулийг зохион байгуулж, 498 хүн нэр дэвшсэнээс 129 эмэгтэй нэр дэвшиж, 13 эмэгтэй гишүүн сонгогдсон нь өмнөх 4 жилтэй харьцуулахад харьцангуй өсөлттэй харагдаж байсан нь сонгуулийн тухай хуулинд оруулсан жендэрийн квотыг 20 хувиар тогтоосны үр дүн байсан. 2020 онд томсогосон мажоритари тогтолцоогоор сонгуулийг явуулсан, 606 хүн нэр дэвшсэнээс 151 эмэгтэй нэр дэвшиж, 13 эмэгтэй гишүүн сонгогдсон төдийгүй УИХ-ын гишүүдийн 7.8 хувь нь буюу 6 гишүүн 40-өөс доош насны залуу гишүүд, түүний дотор 35 нас хүртэлх насны залуу гишүүн 1 сонгогдсон нь насны бүлгийн хувьд төлөөлөл хангах байдал дээр ахиц харагдаж байлаа. Гэвч энэ нь сонгуулийн тухай хуулинд 20 хувийн квот заасантай ихээхэн хамааралтай. Харин 2024 оны улсын их хурлын сонгууль нь сонгуулийн холимог тогтолцоо буюу 78 гишүүн тойрогт, 48 гишүүн жагсаалтаар (нэрсийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй сөөлжүүлэн байршуулснаар), жендэрийн квотыг 30 хувиар хуульчилсантай нягт холбоотой. Улс төрийн 5 нам, 2 эвслийн тойргоос 8 эмэгтэй, 5 нам, эвслийн 24 эмэгтэй жагсаалтаар УИХ-д суудал авсан. Энэ удаагийн сонгуульд нийт 1336 хүн нэр дэвшсэнээс

519 эмэгтэй нэр дэвшиж 32 эмэгтэй гишүүнтэй болсноор түүхэн дээд амжилтыг 8 хувиар ахиулж 25 хувьд хүрлээ. Мөн Олон Улсын Парламентын холбооноос (Inter-Parliamentary Union) парламент дахь эмэгтэйчүүдийн оролцооны түвшнээр 2024 оны 4 дүгээр сарын сарын байдлаар Монгол улс 17 эмэгтэй гишүүний тоогоор 190 улсаас 129 -р байранд бичигдэж байсан. Шинээр сонгогдсон 32 эмэгтэй гишүүний тоогоор 96-99 дүгээр байр байр руу урагшилсан төдийгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл анх удаа УИХ-д сууж байгаа зэрэг олон үр дүн харагдаж байгаа хэдий ч анхаарал татсан зүйлүүд ажиглагдаж байна. УИХ-д сонгогдсон 126 гишүүний 74.6 хувь буюу 94 нь эрэгтэй, 25.4 хувь буюу 32 нь эмэгтэй байна. Үүнээс тойрогт өрсөлдөн сонгогдсон 78 гишүүдийн 90 хувь буюу 70 нь эрэгтэй, 10 хувь буюу 8 нь эмэгтэй байна.

*Хүснэгт 3. Монгол дахь сонгуулийн тогтолцоо ба хууль тогтоох байгууллагын эмэгтэйчүүдийн оролцоо*

№	Сонгуулийн жил	Сонгуулийн тогтолцоо	Нийт нэр дэвшигчид	Эмэгтэй нэр дэвшигчид	УИХ-д сонгогдсон эмэгтэй гишүүдийн тоо	Хувь
1	1992 он	Томсогосон мажоритар	293	10	4	5.2%
2	1996 он	Жижигсэгсэн мажоритар	302	15	5	6.5%
3	2000 он	Жижигсэгсэн мажоритар	602	46	6	7.8%
4	2004 он	Жижигсэгсэн мажоритар	244	26	6	7.8%
5	2008 он	Томсогосон мажоритар	356	62	3	3.9%
6	2012 он	Холимог	544	174	11	14.4%
7	2016 он	Томсогосон мажоритар	498	129	13	17.1%
8	2020 он	Томсогосон мажоритар	606	151	13	17.1%
9	2024 он	Холимог	1336	519	32	25.3%

Эх сурвалж: Сонгуулийн мэдээнд үндэслэн зохиогчийн тооцсоноор

Дээрх хүснэгт дэх тоон мэдээллийг нарийвчлан авч үзвэл сонгуулийн тойрогт өрсөлдөн суудал авсан эмэгтэй гишүүдийн 6 нь МАН, 2 нь АН бусад улс төрийн нам, эвслээс эмэгтэйчүүд тойргоос өрсөлдөн суудал хараахан авч чадаагүй. Энэ бүгдээс үзэхэд хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцоонд сонгуулийн тогтолцоо шийдвэрлэх үүрэгтэй болох нь тодорхой харагдаж байна.

Монгол улс 2020 оны УИХ-ын сонгуулийг мажоритар тогтолцооны нэг хэлбэр болох олон мандаттай том тойргийн (block voting) тогтолцоогоор зохион байгуулсан. Хэрэв улс төрийн сонгуулийн квот байгаагүй бол УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл буурах магадлал өндөр байсан.

Мөн Үндсэн хуулийн 16.11-д “Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй” (МУ -ын Их Хурал, 1992), Улс төрийн намын тухай хуулийн 8.5 -д “Нам бодлого, үйл ажиллагаандаа эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхиээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхолын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог ханган ажиллана”, Мөн хуулийн 8.7-д ЖЭТБХТХ-ийн 8.4-т заасны дагуу намын үйл ажиллагаа дахь жендэрийн эрх тэгш байдлын талаарх тайланг жендэрийн үндэсний хороонд хүргүүлэнэ, 8.8-д Жендэрийн үндэсний хороо энэ хуулийн 8.2.3, 17.7-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дүгнэлтийг жил бүрийн 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор сонгуулийн төв хороонд хүргүүлэнэ гэх мэтээр хуульчилсан. Мөн УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 30.2-т “Нам, эвслээс нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна”, тус хуулийн 30.6-д “Нам, эвсэл жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 хүйсийн харьцаатай жагсаалтын дарааллыг үндэслэн нэр дэвшүүлнэ” гэж эмэгтэй нэр дэвшигчийг дэмжсэн квотыг хуульчилсан. Эдгээр заалтууд эмэгтэйчүүдийг сонгогдох эрхээ эдлэхэд дэмжлэг болохоос гадна сонгуулийн тогтолцоонд гарсан томоохон дэвшил юм

### Дүгнэлт

Манай улсын хувьд 9 удаагийн сонгууль явуулсны 7 мажоритар сонгуулийн тогтолцоогоор явуулсан бөгөөд хамгийн ихдээ 13 эмэгтэй буюу 17.2 хувьд хүрч байжээ. Энэ нь дэлхийд 123 дугаарт эрэмбэлэгдэж, Ази 20.7% болон Дэлхийн 25.1% дунжаас доогуур байсан. Олон улсын туршлагаас үзэхэд парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл, хүйсийн тэгш байдлыг хангахад сонгуулийн пропорционал тогтолцоо нь мажоритар тогтолцоотой улсуудаас хоёр дахин илүү үзүүлэлттэй байгааг харж болохоор байна. 2011 онд “УИХ-ын сонгуулийн тухай хууль”-ийг шинэчлэн баталж, хуулийн 27.2-т “сонгуульд оролцож байгаа нам, эвслээс нэр дэвшиж байгаа хүний 20-оос доошгүй хувь нь эмэгтэйчүүдийн төлөөлөл байна” гэдэг заалтыг баталж 2012 оны сонгуулийг холимог тогтолцоогоор явуулсны үр дүнд 11 эмэгтэй сонгогдсон. Харин 2016 болон 2020 оны сонгуулиар 13 эмэгтэй сонгогдсон нь 20 хувийн квотын нөлөө. Тэгвэл 2024 оны үр дүнг сонгуулийн тухай хуулинд орсон квот, жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 хүйсийн харьцаатай байх заалт, сонгуулийн холимог тогтолцооны нөлөө байсан. Үүнийг тойрогт өрсөлдөн сонгогдсон 78 гишүүдийн 70 нь эрэгтэй, 8 нь эмэгтэй гэсэн тоогоор харж болно. Цаашид шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхийн тулд эрх зүйн орчныг улам сайжруулах, улс төрийн намуудын манлайлалыг нэмэгдүүлэх, сонгогчдын хандлагыг өөрчлөх хэрэгтэй байна.



## The impact of electoral systems on women’s participation in decision- making level

Uuriintuya Nergui<sup>ID</sup>

Doctoral Student, Lecturer in the Department of Mongolian Language and Social Sciences, Teacher School, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

### Abstract

Ensuring gender equality in legislative bodies plays a significant role in establishing democracy, human rights, and equality. The Government of Mongolia has yet to fulfill its commitments and obligations to international organizations, prompting an exploration of opportunities to increase women's participation at the decision-making level. This article examines the state of women's participation in Mongolia's legislative body in connection with changes in the electoral system. The analysis is based on the theory of political electoral systems and empirical research findings on the relationship between electoral systems and women's representation and participation at the decision-making level across countries. It traces the historical developments from 1992 to the present, drawing conclusions about the 2024 election results and highlighting the decisive role of the electoral system in shaping women's participation. This article aims to present the results of implementing and testing a “Mini” lesson method in the “Human and Society” social science methodology course at the Teachers’ School, focusing on student characteristics, interests, and individual differences. The study involved a total of 53 fourth-year students from two groups in the primary education program. Emphasizing the importance of addressing each student’s individual differences, the study highlights the use of Howard Gardner's multiple intelligences test as essential for identifying learner differences.

The findings reveal that effectively organizing “Mini” lessons with role-playing, careful planning, structured teaching, and engaging discussions is key to successful implementation. Within the framework of this goal, it is noted that, in order to enhance the quality and effectiveness of education today, it is important to implement lessons and activities that consider each learner's differences. This aligns with global trends and the theories and concepts proposed by researchers and scholars, suggesting possibilities for incorporating these approaches into educational activities.

**Key words:** Women's participation, quotas, electoral system, political party, gender equality, sustainable development goals

### Ном зүй

Global Gender Gap Report. (2024 оны 06 11). weforum: <https://www.weforum.org/publications/global-gender-gap-report>

International IDEA. (2023). *Global Elections Supercycle*. Stockholm.

Reynolds, A. (1999). Women in the Legislatures and Executives of the World: Knocking at the Highest Glass Ceiling. *World Politics* 51(4), 547-572. <https://dx.doi.org/10.1017/s0043887100009254>.

Skorge, Ø.S. (2023), Mobilizing the Underrepresented: Electoral Systems and Gender Inequality in Political Participation. *American Journal of Political Science*, 67: 538-552. <https://doi.org/10.1111/ajps.12654>

Бат-Оргил.А. (2021). *Сонгуулийн тогтолцоог сайжруулах нь: Харьцуулсан судалгаа*. Улаанбаатар: Судалгааны тайлангийн төсөл.

Гэрэлт-Од.Э. (2020). Монгол улсын их хурлын сонгуулийн тогтолцоо. *Улс төрийн боловсролын академи*, хууд. 20.

Жаргал.Ж., Сарангэрэл.Л. (2012). *Улс төрийн шинжлэх ухаан*. Улаанбаатар.

МУ -ын Засгийн газар. (2020). *Алсын хараа - 2050*. Улаанбаатар.

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр БНСУ-ын КОЙКА ОУБ. (2022). *Монгол дахь эмэгтэчүүдийн улс төрийн оролцоо, гадаад орны туршилага судалгааны тайлан*. Улаанбаатар.

Нэгдсэн Үндэсний Байгууллага. (2016). *Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-30*. Улаанбаатар.